



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

№203 /413/ 2022.11.10

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

"БИДНИЙ БАХАРХАЛ" ТӨСӨЛ НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилсан "Бидний бахархал" төслийн нээлт ҮБХИС-д боллоо. Тус төслийн нээлтийн үйл ажиллагаанд нийслэлийн Баянзүрх дүүгийн Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид оролцсон юм. БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг уг төслийг нээж хэлсэн үгэндээ, "Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх нь Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүнийг хөгжүүлэх, эх оронч ухамсар, хандлагыг бий болгох асуудлын суурь

үндэс болдог. Үүнийг төр, засгаас ихэд анхаарч Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичигт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэргээр нэлээд арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Улс даяараа бахархан тэмдэглэдэг "Монгол бахархлын өдөр", Бүгд Найрамдах Улсаа тунхагласан баярын өдөр удахгүй болох гэж байна.

Энэхүү баярын өдрүүдийн өмнөхөн миний бие дээрх арга

хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж буй "Бидний бахархал" төслийг нээж байгаадаа туйлын баяртай байна. Уг төсөл нь Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, оюутан залууст улс орныхоо тусгаар тогтнолыг дээдлэх, эх орноо хайрлах, эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх, соёлоороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах итгэл, үнэмшлийг төрүүлэх, эрх чөлөөний үнэ цэн, учир холбогдлыг ухааруулан таниулах, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилготой юм" гэлээ. Нээлтийн үйл ажиллагааны үеэр Монгол Улсын баатрууд, энхийг сахуулах ажиллагаа, цэргийн албаны

төрлүүдийг харуулсан үзүүлэн болоод байлдааны техник, хэрэгслийн үзэсгэлэнг дэлгэн харуулсан юм. Үүний дараагаар ЦДБЭЧ-ын уран бүтээлчид нийт сурагчдад зориулан эх орноо хайрлан хамгаалах, эх түүх, соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн урлагийн тоглолтыг өргөн барьсны зэрэгцээ Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн алба хаагчид, ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн коллежийн сонсогч нар үзүүлэх тоглолтоо толилууллаа. Түүнчлэн Монгол Улсын Ардын багш, хурандаа, доктор, профессор Г.Мягмаржав "Монгол эр хүн" сэдвээр илтгэл тавьсан юм.

ЦАХИМ ЦУГЛАРАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



ЗХЖШ-ын МТГ-ын Техникийн хэлтсээс Зэвсэгт хүчний Төрийн цэргийн командлагч, БИЦУГ, нэгтгэл, анги, салбаруудын техник хариуцсан албан тушаалтнуудтай "Зэвсэглэл, цэргийн техникийн

хангалтыг төлөвлөх, удирдах, ашиглалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох нь" сэдэвт цугларалтыг цахимаар зохион байгууллаа. Энэ үеэр ЗХЖШ-ын БСТГ, МТГ-ын МХТХ, Санхүүгийн

хэлтэс, Зэвсэгт хүчний тээврийн хяналтын алба болон 011 дүгээр ангиас цугларалттай холбоотой сургалтыг нэмэлтээр явуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 1	☁️ -12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,425	3,430
EUR 🇪🇺	3,418	3,440
CNY 🇨🇳	469	471
RUB 🇷🇺	52.65	52.30
JPY 🇯🇵	23.70	24.20
KRW 🇰🇷	2.47	2.50

ЗУРХАЙ



2022.11.10 / ПҮРЭВ ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 17

**НАМРЫН АДАГ ЦАГААН
НОХОЙ САР
ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өнгө зүс доройтно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.50-17.22

Барилдлага:

Үл тохирох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Авахуй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 638,843,596

Эдгэрсэн

Нийт: 618,553,439

Нас барсан

Нийт: 6,609,952

Цахим шууданд

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 186 ДУГААР АНГИД...



БУУДЛАГА АМЖИЛТТАЙ

2022 оны II ээлжээр Цэргийн жинхэнэ албанд татагдан цэргийн мэргэжил эзэмших сургалтдаа хамрагдаж байгаа дайчид энэ сарын 8-ны өдөр автоматын анхны дасгалаа боловсруулла. Буудлагын үед аюулгүй ажиллагааны зааварчилгааг бие бүрэлдэхүүнд танилцуулах, чанд сахиулах үйл ажиллагааг "Сургалтын тав"-ын офицер, ахлагч нар хариуцан ажиллав. Буудлага явуулах хугацаанд дайчдын сэтгэл зүй тогтвортой сэтгэгдэл өндөр байсан юм.



"НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ"-ИЙГ ӨДӨР БҮР

Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчин, анги байгууллагын үйл ажиллагааг ард иргэдэд сурталчилж иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалт, сэтгэл зүйн бэлтгэл, өдөр тутмын үйл ажиллагаа хэрхэн явагдаж буй байдал, тэдний алба хаах орчин, нөхцөлийг танилцуулах зорилгоор "байлдагчийн нэг өдөр" нээлттэй хаалганы өдөрлөгийг өдөр бүр зохион байгуулж байна.



ХҮЙТНИЙ УЛИРЛЫН ДҮРЭМТ ХУВЦСАНД ШИЛЖҮҮЛЛЭЭ

ЗХЖШ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн тушаалыг үндэслэн энэ сарын 7-ны өдөр ангийн захирагчийн тушаалаар ангийн офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид хүйтний улирлын дүрэмт хувцсандаа шилжлээ. "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм"-ийн дагуу байнгын бие бүрэлдэхүүнд албаны болон хээрийн хувцас хэрэглэлд үзлэг явуулан зөрчил дутагдал заагдсан цэргийн алба хаагчдад хугацаат үүрэг өгч, алдаа дутагдлыг засууллаа.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ

ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчинд Цэргийн сургалт бэлтгэлийн алба үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүний дунд цэрэгжлийн спорт, нийтийн биеийн тамир, оюуны болон хөгжөөнт, цогцолбор тэмцээнийг зохион байгуулан явуулж байна.

Тэмцээнийг 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл зохион явуулах ба тэмцээн уралдаанаас гадна бие бүрэлдэхүүний хувь хүний хөгжил, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт, лекцийг явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Ахлах дэслэгч С.СУВДАНЧИМЭГ

АРТИЛЛЕРИЙН МЭРГЭЖЛИЙН АВАРГУУД ТОДРОВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу "Артиллерийн буудлага, гал удирдах бэлтгэлийн аварга" шалгаруулах бодлогын уралдааныг хоёр үе шаттайгаар 2022 оны 01 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд амжилттай зохион байгуулж

явууллаа.

Тус тэмцээнд нийлбэр дүнгээр офицеруудын төрөлд Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн албаны дарга, ахмад Б.Мөнх-Эрдэнэ 93 оноогоор I байр, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн артиллерийн дарга, хошууч Н.Баярсайхан 88 оноогоор II байр,

Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн артиллерийн тагнуулын дарга ахмад Б.Ганцог 86.5 оноогоор III байр эзлэв

Ахлагчийн төрөлд Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн артиллерийн батарейны ахлагч, ахлах ахлагч П.Жавхлантагс 96.5 оноогоор I байр, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн артиллерийн дивизионы ахлагч, сургагч ахлагч Б.Булган 94 оноогоор II байр, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн батарейны ахлагч, сургагч ахлагч Д.Мөнх-Эрдэнэ 80,5 оноогоор III байр, цэргийн гэрээт алба хаагчийн төрөлд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн артиллерийн дивизионы тийрэлтэт артиллерийн батарейны 1 дүгээр галт салааны 1 дүгээр тоотын сумлагч, байлдагч Э.Анхбаяр 86 оноогоор I байрыг тус тус эзэлсэн амжилт үзүүлээ.

Тэмцээнд тэргүүлсэн офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн тушаалаар үнэ бүхий зүйлээр шагнагдав.

Дэд хурандаа М.ГАНТУЛГА

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ДЭРГЭДЭХ "ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ"-ӨӨС ОРОН НУТАГТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Батлан хамгаалахын сайдын батласан удирдамжийн дагуу "Иргэний зөвлөл"-ийн гишүүн УБХИС-ийн хүндэт профессор А.Гэлэгжамцаар ахлуулсан ажлын хэсэг энэ сарын 2-4-ний өдрүүдэд Өмнөговь, Дундговь аймгууд дахь Зэвсэгт хүчний анги, салбарын бие бүрэлдэхүүнд "Хувь хүний хөгжил, харилцаа хандлага, цэргийн алба хаагчийн ёс зүй" сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа.



Түүнчлэн офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад "Эх орноо хайрлахуй" сэдвээр нийт 16 цагийн багц сургалт зохион байгуулж тэдний санал сэтгэгдлийг сонссон юм. Сургалтын төгсгөлд "Батлан хамгаалах яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа", "Зөв харилцаа-Зөв хандлага" цахим нөлөөллийн аяны хүрээнд хийсэн богино хэмжээний дүрс бичлэг үзүүлэв.

"ХАВДРЫН ЭСРЭГ ХӨГЖМӨӨР НЭГДЭЦГЭЭЭ" АЯН ҮРГЭЛЖИЛСЭЭР...



ЦДБЭЧ-ын хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн "Хөгжим эмчилгээ"-ний хөтөлбөрт нэгдэж мэргэжлийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласаар байна.

Эмнэлгийн орчинд эерэг тааламжтай уур амьсгалыг бүрдүүлэх, өвчтөн, үйлчлүүлэгчдийг сэтгэл зүйн хувьд тайвшруулах, эмчилгээний үр нөлөөг хөгжим, урлагийн бүтээлээр дэмжих зорилго бүхий "Хөгжим эмчилгээ"-ний өдөрлөгийн хүрээнд ЦДБЭЧ-ын үндэсний хөгжмийн цөөхүүл бүрэлдэхүүн шилдэг бүтээлүүдээсээ бүрдсэн тоглолтыг зохион байгууллаа.